



ADB

JFPR
Japan Fund for Prosperous and
Resilient Asia and the Pacific



From
the People of Japan



УЛААНБААТАР ХОТЫН
ХҮНСНИЙ ХОГ ХАЯГДЛЫГ
ДАХИН БОЛОВСРУУЛАХ ТӨСӨЛ

elf
curriculum

ЖОГОН МАНГАСЫН ДЭЛХИЙГ ЭЗЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ



“ХОГОН МАНГАСЫН ДЭЛХИЙГ ЭЗЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ”

Энэхүү номыг Азийн хөгжлийн банктэй хамтран Ази, Номхон далайн бүсийн тогтвортой хөгжлийн Япон сангийн санхүүжилтээр хэрэгжиж буй “9202-МОН: Улаанбаатар хотын хүнсний хог хаягдлыг дахин боловсруулах төсөл”-ийн захиалгаар “Элф Хөтөлбөр” ХХК бэлтгэн боловсруулав.

Элф Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч цэцэрлэгүүдэд энэхүү төслийг Нямм Нямм модультай хослуулан хэрэгжүүлэн хог хаягдлыг бууруулах сайн үйлсэд үнэ цэнтэй хувь нэмэр оруулдаг хүүхдийг бүтээх болно.

Та бүхний ажилд амжилт хүсье.

Зохиолч: Б. Солонго

Зураач: Э. Нямцэцэг
А. Энхдаваа

ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА:

Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас Азийн хөгжлийн банктэй хамтран Ази, Номхон далайн бүсийн тогтвортой хөгжлийн Япон сангийн 3 сая долларын санхүүжилтээр “9202-МОН: Улаанбаатар хотын хүнсний хог хаягдлыг дахин боловсруулах төсөл”-ийг 2020-2024 онд хэрэгжүүлж байна.

Төслийн зорилго нь хүнсний хаягдлыг дахин боловсруулах технологийг иргэдийн оролцоотойгоор нэвтрүүлэх, эрүүл, аюулгүй орчин болон эдийн засгийн өсөлттэй, ногоон, тогтвортой хөгжлийг бий болгоход оршино.

Төслийн үйл ажиллагаа нь дараах 3 үр дүнд чиглэсэн. Үүнд:

- Хүнсний хаягдлыг дахин боловсруулах хувилбаруудыг тодорхойлох.
- Хүнсний хаягдлыг иргэдийн оролцоотойгоор дахин боловсруулах.
- Хүнсний хаягдлыг дахин боловсруулах ажлыг өргөжүүлэх хөтөлбөр боловсруулах.

☎ 976 7775 2223

✉ office@ubfoodwaste.mn

🌐 www.ubfoodwaste.mn

📍 “ХАЙРЛА”

📍 “Улаанбаатар Хотын Хүнсний Хог Хаягдлыг Дахин Боловсруулах Төсөл”

📍 Khairla_




**ДЭЛХИЙ ДЭЭР ХҮН, АМЬТАН, УРГАМАЛ
БҮГД АЗ ЖАРГАЛТАЙ АМЬДАРЧ БАЙВ.**




**ТЕХНИК ТЕХНОЛОГИ ХУРДАЙ ХӨГЖИЖ,
ХҮНИЙ БУРУУТАЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА,
ҮЙЛДВЭР, ХООЛНЫ ГАЗАР, ХУВЦАС
ТОГЛООМЫН ХЭРЭГЦЭЭ НЭМЭГДЭЖ
ДЭЛХИЙД ХОГОН МАНГАСУУД БИЙ БОЛОВ.**

**НОМЫН ДҮРҮҮДИЙН СЭТГЭЛ ХӨДЛӨЛИЙГ
ТАНЬЖ БУДААРАЙ.**








ОЛОН ТӨРЛИЙН ХЭРЭГЦЭЭГҮЙ
ХУВЦАСНУУД МАШ ИХ БОЛЖЭЭ.
МИНИЙ ХҮЧ НЭМЭГДЭХЭД
ЭД НАР Ч ҮНЭХЭЭР ИХ
ТУС БОЛНО ДОО.



ХҮМҮҮС Ч ҮНЭХЭЭР ИХ
ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ
АШИГЛАХ ЮМ АА.
БҮГДИЙГ НЬ ЭЗЛЭЭД ХАМГИЙН
ХҮЧИРХЭГ МАНГАС
БОЛНО ОО.




ХҮҮХДУУД ТОГЛОМОО
ЭВДЭЖ ХАЯАД Л БАЙВАЛ
МИНИЙ ХҮЧ ЧАДАЛ
НЭМЭГДЭХ БОЛНО.




УСЫГ Ч ҮНЭХЭЭР САЙН
БОХИРДУУЛЖ БАЙНА ШҮҮ.
БҮГД МИНИЙХ.
ГОЁ ДОО!!!





ЯМАР ИХ ШИМ ТЭЖЭЭЛГҮЙ
ХООЛНЫ ХАЯГДАЛ ВЭ?
САЙХАН ДАА,
БҮГДИЙГ НЬ ЭЗЭЛНЭ
ДЭЭ.










ХОГ ХАЯГДЛЫГ
БУУРУУЛАХ
ШИЙДЛҮВДИЙГ
УСТГАХ
ТӨЛӨВЛӨГӨӨ




БҮГДЭЭРЭЭ ХҮМҮҮСИЙН ХОГ
ХАЯГДЛЫГ БУУРУУЛЖ БАЙГААГ НЬ
ЗОГСООЁ.
ДАРАА НЬ ДЭЛХИЙГ БҮХЭЛД НЬ
ЭЗЭЛЬЕ!










ХОГОН МАНГАСУУД НЭГДЭЖ АВАРГА ТОМ

СУПЕР




МАНГАСЫГ БҮТЭЭВ.




БИ БОЛ ДЭЛХИЙГ ЭЗЛЭХ
СУПЕР ХОГОН МАНГАС!!!




ҮРГЭЛЖЛЭЛ БИЙ...






ГАДАА БАЙГАА МАНГАС
ХААНААС ГАРААД ИРЭВ ЭЭ?
БИ НАЙЗУУДАА ХЭЛЭХ
ЁСТОЙ.



НАЙЗУУД АА!
ЭНЭ МАНГАС БИДНИЙ ТАРЬСАН
ХОГНООС ҮҮССЭН БАЙНА.
ТҮҮНИЙГ УСТГАХЫН ТУЛД
БҮГДЭЭРЭЭ ХОГ
ХАЯГДЛАА
БУУРУУЛЦГААЯ!!!



ХӨӨХ!!!
ЗА, ОЙЛГОЛОО
НАЙЗ АА.





БИ АЯГАЙ ХООЛОО
ДУУСТАЛ ИДНЭ ЭЭ.

ХООЛНЫ
ХАЯГДАЛ УЛАМ
БАГАСААД БАЙХ
ЧИНЬ?




БИ ХҮҮХЭД БҮР
ТОГЛОЖ БОЛОХ,
ОЛОН ТӨРЛИЙН
ХЭЛБЭРТ ХУВИРДАГ
УХААЛАГ ТОГЛОМ
ЗОХИОН БҮТЭЭНЭ ЭЭ.

ТОГЛОМ ХАЯГДАХГҮЙ
БОЛ БИ УДАХГҮЙ
УСТАХ БАЙХ ДАА?







БИ УДАХГҮЙ
ЯМАР Ч ХҮЧГҮЙ
БОЛОХ НЬ ЭЭ.

БИ ТОМ БОЛСОН Ч ГЭСЭН
ӨМСӨЖ БОЛОХ УДААН
ХЭРЭГЛЭГДЭХ ХУВЦАС
ХИЙХ БОЛНО.



УСАА ХЭМНЭЖ,
ХАЙРЛАЖ, ЗӨВ
ЗОХИСТОЙ
ХЭРЭГЛЭЦГЭЭ!


МИНИЙ ХҮЧ
СУЛАРЧ БАЙГАА НЬ
МЭДРЭГДЭЖ БАЙНА!




**БИ ГАР УТАС, КОМПЬЮТЕР
ЗЭРЭГ ОЛОН ТӨРЛИЙН
ЦАХИЛГААН ТӨХӨӨРӨМЖИЙГ
НЭГТГЭЖ ГАНЦХАН ЧУХАЛ
ХЭРЭГСЭЛ ХИЙХ БОЛНО.
БАС АХУЙН ЦАХИЛГААН
ХЭРЭГСЛЭЭ ГАМНАЖ
ХЭРЭГЛЭНЭ ЭЭ.**



**МИНИЙ ХҮЧ БУУРЧ БАЙНА.
ЭНЭ МИНИЙ УУРЫГ ХҮРГЭЖ
БАЙНА.**





**ДЭЛХИЙ МАШ
ЦЭВЭРХЭН БОЛЧИХЛОО.
ОДОО БИ ЯАНА АА?**

**ХҮМҮҮС ЗӨВ
ҮЙЛДЭЛ ХИЙСЭЭР Л
БАЙНА...**



**ХҮМҮҮС БИДНИЙ ХҮЧИЙГ УСТГАЖ
ЧАДЛАА. ХЭДҮҮЛЭЭ ДЭЛХИЙГ
ЭЗЭЛЖ ЧАДСАНГҮЙ.
БИД ЯЛАГДСАН БОЛОЛТОЙ.**



ДҮРЭМ

1. Хоолоо дуустал нь идэж хоолны хог хаягдал гаргахгүй байх

2. Усаа хэмнэж, усаа хайрлах, усыг бохирдуулахгүй байх

3. Олон тоглоом авч их хог хаягдал бий болгохгүй байх

4. Бий болгосон хог хаягдлыг ангилж хаях, ахин боловсруулах мэдээлэлд сурах

5. Найзууддаа хогийг бага гаргах, эх дэлхийгээ хайрладаг байх, ногоон дэлхий бүтээхэд нөлөө үзүүлэхийг уриалах

Эдгээр дүрмийг биелүүлнэ гэдгээ амлаж байна.



